



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/408

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Эс Жи Эм” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Сургуулийн барилгын их засвар /Ховд, Чандмань сум/-н ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг Даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Д.Нямтулга

- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын  
техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг Даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

З.Өмиртай - Газрын харилцаа, барилга хот байгуулалтын  
газрын Барилга, хот байгуулалтын  
хэлтсийн дарга

Д.Цогтхүү - Стандарт хэмжил зүйн хэлтсийн байцаагч

З.Онолбаатар - Чандмань сумын Засаг дарга

Ш.Пүрэвдамба - Чандмань сумын сургуулийн захирал

Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,  
эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

С.Лхагва-Оргил - “Эс Жи Эм” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын мэргэжилтэн

2. “Эс Жи Эм” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Дээрх ажилтай холбогдолтой гарах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН